



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/50

Эмээлтолгой

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, "Мал амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/187 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тэмцэх заавар"-ын 2.5.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нам толгой 1 дүгээр багийн шүлхийн голомттой бүсийн мал сүрэгт хязгаарлалтын дэглэм тогтоосон хугацаанд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй тул сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/41 дүгээр захирамжаар тогтоосон хязгаарлалтын дэглэмийг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн цуцалсугай.

2. Малчин өрхүүдэд өөр аймаг, сум болон өөрийн сумын багийн нутагруу хүн, мал, тээврийн хэрэгслийн шилжит хөдөлгөөн хийхгүй байх, өвчний талаар мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулахыг багийн Засаг дарга (Ч.Цэдэвсүрэн), "Давхарын нуруу" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Б.Болормаа)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ

